

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг шинээр авахад
бүрдүүлэх материал, хугацаа, хаана хандах

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1. “Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.7.1, 15.7.2, 15.7.4, 15.7.8, 15.7.9, 16.2.4, 16.3.3-д заасны дагуу их сургууль, дээд сургууль, коллежид, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус олгоно.”

Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

Боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулагч нь тусгай зөвшөөрөл авахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эхлэхээс зургаагаас доошгүй сарын өмнө тусгай зөвшөөрөл олгох байгууллагад ирүүлнэ.

1.боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, өргөдөл, дүрэм, үүсгэн байгуулах тухай гэрээний аль нэг;

2.боловсролын сургалтын байгууллага байгуулах үндэслэл, тооцоо бүхий танилцуулга;

3.сургалтын төлөвлөгөө;

4.багшлах боловсон хүчний хангамж, бүрэлдэхүүн, боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа;

5.сургалт явуулах барилга байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг зэрэг сургалтын хэрэглэгдэхүүний баталгаа;

6.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа;

7.үүсгэн байгуулагчаас сургалтын байгууллагын мэдэлд шилжүүлэх хөрөнгө /биет болон мөнгөн/-ийн жагсаалт, хэмжээ, баталгаа;

8. байгууллагын эзэмшил газрын зөвшөөрөл.

Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

1.Тусгай зөвшөөрлийг 5 жилээс доошгүй хугацаагаар олгоно.

2.Тусгай зөвшөөрлийн хугацааг он, сар, өдрөөр тодорхойлох бөгөөд тухайн сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн тоолно.

3.Хугацаа сунгуулах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас гурван сарын өмнө гаргана.

4.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1-д заасан нөхцөл байдал илрээгүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацааг сунгана.

Тусгай зөвшөөрлийн талаар хаана хандах

Боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулагч нь тусгай зөвшөөрлийн баримт бичгийг бүрдүүлж, аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газарт ирүүлнэ.

Хаяг: Арвайхээр сум. 5 дугаар баг. Нутгийн Удирдлагын Ордоны 4 давхар. Боловсрол, соёл, урлагийн газар. Холбогдох утас: 70322105, 94042105, 70323086